



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



From  
the People of Japan



Save the Children

## “ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ-2” ТӨСӨЛ (2021-2024)

МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС № 8

2024 оны 2-р сар



79-р сургуулийн Сурагчдын Өөрөө Удирдах Зөвлөлийн гишүүд мэдээлэл танилцуулж байна.

Баянзүрх дүүргийн 79-р сургуулийн урлагийн танхим, “Тэгш хамруулах боловсрол” олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа, 2023.10.26

# “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР КОМИСС, СУРГУУЛИЙН ДЭМЖЛЭГИЙН БАГИЙН ХАМТАРСАН ЗӨВЛӨЛДӨХ-УУЛЗАЛТ

2023 оны 5-р сар

2023 оны 5-р сард Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамнаас Монгол улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал (ХБХЭМБНХ)-ын салбар комиссын бүх гишүүдийг хамруулсан сургалтыг НҮБ-ын Хүүхдийн сан, Жайка, Норвегийн хамтын ажиллагааны байгууллага, Азийн хөгжлийн банктай тус тус хамтран зохион байгууллаа.

Сургалт нь Улаанбаатар хотод 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Миллениум зочид буудлын хурлын танхимд болж, нийт 210 хүн оролцсон бөгөөд аймаг, дүүргийн ХБХЭМБНХ-ын салбар комиссын гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Мэдээллийн нэгдсэн сан”-г ашиглах аргачлалыг танилцуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, чадавх бэхжүүлэх зорилготой байлаа.

Түүнчлэн ХНХЯ-тай хамтран 2023 оны 10-р сарын 31-ны өдөр Монгол-Япон төвийн сургалтын танхимд Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн ХБХЭМБНХ-ийн салбар комисс, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, УБ хотын зорилтот сургуулиудын дэмжлэгийн багийн төлөөллүүдийг хамруулсан зөвлөлдөх-уулзалтыг зохион байгууллаа. Уг зөвлөлдөх-уулзалтад

дээрх байгууллагуудын төлөөлөл болох нийт 45 хүн оролцлоо.

Дээрх зөвлөлдөх уулзалтуудаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хүрээнд хүүхдийн хөгжлийн хоцрогдол бэрхшээлийг эрт илрүүлэх, эрт үеийн хөгжлийн дэмжлэг оролцооны үйлчилгээнд хамруулахад ХБХЭМБНХ-ын комиссын үүрэг оролцоо, тэгш хамруулдаг сургуулийг бий болгоход сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн багийн оролцоо, орон нутгийн түвшинд Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, олон нийтэд түшиглэсэн бага насны хүүхдийн хөгжлийн төв, ХНХ-ын сайд, БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал” маягтыг шинэчлэн батлах тухай хамтарсан тушаалын хэрэгжилт, хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг сэдвээр танилцуулга мэдээлэл хийлээ.



21 аймаг, 9 дүүргийн салбар комиссын сургалт, 2023.05.16



Зорилтот дүүрэг, сургуулийн салбар комисс, дэмжлэгийн багийн үүлзлэлт, 2023.10.31



БШУЯ-ны мэргэжилтэн Ч.Жаргал мэдээлэл хийж байна



ХНХЯ-ны мэргэжилтэн Ч.Ариунболор оролцогчдоос тавьсан асуултад хариулж байна.



СХД-ийн салбар комиссын гишүүн, ГБХЗХХ-ийн мэргэжилтэн А.Долгорсүрэн санал хэлж байна.

# “ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ” ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 оны 10-р сар



79-р сургуулийн сурагчид өөрсдийн сонирхсон чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө авлаа. 2023.10.26

Тэгш хамруулах боловсролын талаар эцэг эх, багш, сурагчид, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор “Тэгш хамруулах боловсрол” олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг 2023 оны 10 дугаар сарын 26-нд нийслэлийн Баянзүрх дүүргийн 79-р сургуулийн урлагийн зааланд зохион байгууллаа.

Энэ жилийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран, илүү өргөн хүрээнд олон нийтийг хамруулж зохион байгуулснаараа онцлогтой байлаа. Тус арга хэмжээний үеэр 300 гаруй багш, эцэг эх, сурагчид өөрсдийн сонирхсон чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас үнэ төлбөргүй мэдээлэл, зөвлөгөө авч, тусгай хэрэгцээт хүүхэдтэй харилцах, тэдэнтэй ажиллах талаар мэдлэг ойлголтоо бэхжүүллээ.



Монголын Дауны Холбооны төлөөлөгчид мэдээлэл өгч байна. 2023.10.26

“Тэгш хамруулах боловсрол” олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлын хамтран зохион байгуулагчаар Монголын Аутизмын холбоо, Монголын Дауны холбоо, Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, Сонсголгүйн боловсрол ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Төслийн зорилтот сургуулийн СӨУЗ гишүүд, багш нар оролцов.



79-р сургуулийн сурагчдын өөрөө удирдах зөвлөлийн гишүүд мэдээлэл өгч байна. 2023.10.26



# “ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ” ҮНДЭСНИЙ СЕМИНАР

2023 оны 11-р сар

Төслийн үр дүн, туршлагыг хуваалцах “Тэгш хамруулах боловсрол” үндэсний семинар 2023 оны 11 дүгээр сарын 20-21-нд Улаанбаатар хотод боллоо. Үндэсний семинарт аймаг, дүүргийн Боловсролын газар, хэлтсийн тэгш хамруулах боловсрол хариуцсан 32 мэргэжилтэн оролцлоо.

Семинарыг нээж, “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн Менежер Фуми Мацумото хэлсэн үгэндээ “Та бүхэн манай төслийн хүрээнд зөвлөх багуудын боловсруулсан тэгш хамруулах боловсролын сургалтын модулиудыг судална. Эндээс сурч мэдсэн зүйлсээ өөрсдийн орон нутагтаа түгээн дэлгэрүүлэхийг би та бүхнээс хүсэж байна” хэмээн дурдлаа. Оролцогчид төслийн хүрээнд боловсруулсан сургалтын модулиудын түлхүүр агуулгатай танилцаж, арга зүйд нь суралцав. Семинарын хоёр дахь өдөр оролцогчид Чингэлтэй дүүргийн 37 дугаар дунд сургууль, Хан-Уул дүүргийн 63 дугаар тусгай сургууль, Баянзүрх дүүргийн 79 дунд сургууль, 55 дугаар тусгай сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, эдгээр сургуулиудад хэрэгжсэн төслийн туршлага, тусгай хэрэгцээтэй хүүхдийг хөгжүүлэх, сэргээн засах төвүүдийг үзэж сонирхлоо.

Баян-Өлгий аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Сургалт, судалгаа, арга зүйн асуудал хариуцсан хэлтсийн дарга А.Еркегүл хэлэхдээ “Өнөөдрийн сургалтаар тусгай хэрэгцээт боловсролын



Сургалтад оролцогчид, Улаанбаатар хотын Инновацийн төв, сургалтын танхим, 2023.11.20. Улаанбаатар хот.



Сургалтад оролцогчид 79-р сургуулийн Хүүхэд хөгжлийн танхимын үйл ажиллагаатай танилцаж байна. 79 дүгээр сургуулийн ХХТ, 2023.11.21. Улаанбаатар хот.

талаарх мэдлэгээ улам өргөжүүлж, хүүхэд бүрийн онцлогт тохирсон арга, зүй, хөтөлбөрөөр боловсролыг хүртээмжтэй байдлаар хэрхэн хүргэх болон эрх зүйн орчны талаар ойлголт авсан. Хүүхдийг Ивээх Сангаас гаргасан тэгш хамруулах боловсролын талаарх гарын авлага, номыг боловсруулсан зөвлөх багийн багш нараас ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах арга зүйд суралцлаа” хэмээн ярилаа. Мөн Говь-Алтай аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамруулах боловсрол хариуцсан мэргэжилтэн Д.Баатархүү “Бид сургуулиуд дээр очиж, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан Хүүхэд хөгжлийн танхим, сургалтын материал, багш нарын хүүхэдтэй хэрхэн ажиллаж байгаатай танилцлаа. Эдгээр сургуулиудад тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан тайвшруулах өрөө, ариун цэврийн өрөө, налуу шат, туслах тоноглол зэрэг зүйлүүд хийжээ. Санаа авах зүйлүүд их байна” гэж сэтгэгдлээ хуваалцав.

# СУРАГЧДЫН ӨӨРИЙГӨӨ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН СУРАГЧИД, ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 он

Манай зорилтот сургуулийн СӨУЗ-ын сурагчид сурагчдын суралцах арга барил, сонирхол хэрэгцээнд тохируулан үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа суралцаж, хөгжих үйл ажиллагаануудыг “Найзын хөтөлбөр” аяны хүрээнд төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулж байна. Эдгээрээс онцлох үйл ажиллагааг дурдвал:

79 дүгээр  
сургууль

“Би гэр бүлдээ, сургуульдаа үүнийг хүсдэг” зургийн уралдааныг тусгай хэрэгцээтэй хүүхдийг оролцуулан зохион байгуулж тэдний хүсэл, дуу хоолойг зургаар дамжуулан гаргасан. Энэхүү уралдааны дараа тэдгээр хүүхдүүдийн гэр бүл, ойр дотны хүмүүстэй уулзан ярилцаж тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

127 дугаар  
сургууль

Нийт сурагчдын дунд гар утасны хэрэглээг багасгаж ном унших уриалга гарган “Идэвхтэй уншигч” аяныг жил бүр зохион байгуулж байна. Сургуулийн номын санд заавал унших номын жагсаалт гаргаж хуваарь гаргаснаар номын санд ирдэг хүүхдийн тоо 50%-иар нэмэгдсэн байна.

65 дугаар  
сургууль

Тусгай хэрэгцээт боловсрол, хүүхдийн талаар контент сурагчдад үзүүлж, үүнийхээ дараа сурагчдын дунд ярилцлага өрнүүлж нөлөөллийн ажлыг зохион байгуулжээ.

67 дугаар  
сургууль

“Идэвхтэй уншигч” аян тус сургуулийн брэнд үйл ажиллагаа болсон. Энэ аяны үеэр сурагчид харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд том үсэгтэй унших ном хийх, сурагчдад унших хурдаа сайжруулах, уншиж сурах зэрэгт нь тусалдаг байна.

## 37 дугаар сургууль

Сурагч солилцоогоор ахлах ангийн сурагчдад бага ангийн хүүхдүүдийг даалган өгч хамт хичээлд сууж, суралцахад нь дэмждэг. Энэхүү үйл ажиллагааг сурагчдын зөвлөлөөс уламжлал болгон зохион байгуулж байна.

## 49 дүгээр сургууль

Бага ангийн сурагчдыг дунд ангийн анги танхим, сургуулийн бусад газраар зочлуулах, сургуулийн удирдлага, дунд ангийн багш нар, сурагчдын оролцооны байгууллага, тэдний үйл ажиллагаатай танилцуулах хөтөлбөр гарган жил бүр зохион байгуулдаг.

## Өвөрхангай, Арвайхээр хотын 2 дугаар сургууль

“Би чадна” үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулж тусгай хэрэгцээтэй хүүхдүүд юуг сайн хийж сурсан бүтээлээрээ үзэсгэлэн гаргаж оролцдог.

## Ховд, 7 дугаар сургууль

“Найзын хөтөлбөр” аяны хүрээнд ахлах ангийн сурагчид хичээлийн дараа бага ангийн сурагчидтай 7 хоногт 2 цаг хичээл давтах, унших, тоо бодоход нь туслах зэргээр хамтдаа хичээллэдэг.



“Хамтдаа дэвшин суралцъя” сурагчдад зориулсан сургалт. 2023.10.10, Баянзүрх дүүргийн 127-р сургууль



Бага ангийн сурагчид дунд ангийн үйл ажиллагаатай танилцаж байна. 2023.12.04, Чингэлтэй дүүргийн 39-р сургууль

# “БҮХ ХАЙРАА ГЭР БҮЛДЭЭ ЗОРИУЛЬЯ” СЭДЭВТ НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 оны 12-р сар

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын 2-р дунд сургуульд төслийн Модуль 3-ын хүрээнд “Бүх хайраа гэр бүлдээ зориулъя” сэдэвт нөлөөллийн үйл ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа.



**Ахлах ангийн 27 сурагч, 29 эцэг, эх хамтаар оролцсон уг арга хэмжээ нь 1 өдрийг хүүхдээ анзаарч, хүүхдэдээ цаг гаргах боломж, нөхцөл, орчныг бүрдүүлсэн.**

Энэхүү үйл ажиллагаа нь эцэг эх, асран хамгаалагчдыг сургуулийн үйл ажиллагаанд татан оролцуулах, өсвөр насны хүүхэдтэйгээ халуун дотно яриа өрнүүлэх, хамтдаа дурсамж бүтээх, тэгш хамруулан сургах боловсролын талаар ойлголт, хандлагыг өөрчлөх зорилгоор зохион байгууллаа.

Ангийн сурагчид эцэг эхийн хамт “Хамтдаа суралцъя”, “Хамтдаа бүтээе”, “Хамтдаа дуулъя”, “Хамтдаа тоглоё”, “Хамтдаа ярилцъя” гэсэн 5 өртөөгөөр аялан даалгаврыг хамтдаа биелүүлэх, ярилцах боломжийг олгож сурагчид өөрийн эцэг эхчүүдтэй харилцан ярилцаж, өөрсдийн сэтгэлийн гүн дэх бодол мэдрэмжийг хамтдаа хуваалцлаа.

Өдөрлөгийг дүгнэж эцэг эхчүүд, хүүхдүүд энэ үйл ажиллагааг ахлах ангийн сурагчдад уламжлал болгон зохион явуулах хэрэгцээ шаардлага байгаа талаар санал хэлж, эцэг эх хүүхэдтэйгээ хамт байх, тэдний хүүхэд насны дурсамжийг хамтдаа бүтээх боломжийг бүрдүүлсэн бөгөөд цаашид энэхүү үйл ажиллагааг бусад

ангиуддаа жил бүр уламжлал болгон зохион байгуулах саналыг эцэг эхчүүд өгснөөс гадна бусад сургуулиудад ч гэсэн зохион байгуулах ажлыг аймгийн БШУГ анхааралдаа авч, ажил хэрэг болгох санал гаргалаа.



Эрдэнэцэцэг багштай 11Д ангийн сурагч А ээжийн хамт Арвайхээр 2-р сургуулийн ангид бүтээл хийж байгаа нь 2023.12.16





Эрдэнэцэгэ багштай 11Д ангийн сураач Б аав ээжийн хамт Арвайхээр 2-р сургуулийн ангид бүтээл хийлээ.  
2023.12.16



11 Д ангийн хамт олон эцэг эхчүүдийн Арвайхээр 2-р сургуулийн ангид "Хамтдаа бүтээе" өртөө дээр бүтээл хийж байгаа нь  
2023.12.16



Нийт эцэг эх, асран хамгаалагч, сурагчдын хамтарсан бүтээлийн зураг  
2023.12.16



11 Д ангийн хамт олон эцэг эхчүүдийн хамт 11 Д ангийн хамт сургуулийн урлаг зааланд олон эцэг эхчүүдийн хамт үйл ажиллагаанд оролцож байгаа нь  
2023.12.16



11 Д ангийн хамт олон эцэг эхчүүдийн хамт 11 Д ангийн хамт сургуулийн урлаг зааланд эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ авахуулсан гэр бүлийн зургаа танилцуулж байна.  
2023.12.16

# МУИС-ИЙН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛИЙН ОЮУТАН Б.ЖАВЗАН

2023 он

Ховд аймгийн төслийн зорилтот сургуулийн нэг болох ЕБС-ын 7 дугаар дунд сургууль нь “хүүхэд бүрийн нийгэм, сэтгэлзүй, танин мэдэхүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх, тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан амжилттай суралцах тэгш боломж бүрдүүлэх” зорилтыг дэвшүүлж, аймагтаа тэгш хамруулах сургуулийн загвар болон ажиллаж байгаа сургууль билээ.

Тус сургуульд 2011-2023 онд суралцаж төгссөн Б.Жавзан охин хөгжлийн бэрхшээлтэй хэдий ч сургуульдаа амжилттай суралцаж, элсэлтийн ерөнхий

шалгалтаа Монгол хэл, Нийгмийн хичээлээр өгч, өөрийн эзэмшихийг хүссэн мэргэжил болох Сэтгэл судлалын мэргэжлээр Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургуульд 1 дүгээр курст суралцаж байна.

Б.Жавзан охин элсэлтийн ерөнхий шалгалтдаа бэлтгэхдээ төслийн зүгээс зорилтот сургууль бүрт тохижуулж өгсөн Хүүхэд хөгжлийн танхимд хичээллэн, Монгол хэл, Нийгмийн ухааны хичээлийн багш нартайгаа ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу суралцжээ.

## Б.Жавзан охин ярихдаа:

“...Намайг шалгалтад бэлтгэсэн 2 багшдаа маш их баярладаг. Бас ангийн багшдаа, ангийн хүүхдүүддээ маш их баярладаг. Их сургуульдаа ороход манай 7-р сургуулийн захирал, сургалтын менежер, ангийн багш, шалгалтад бэлтгэсэн багш нар маань ирж манай ангийнхантай уулзаж, надад амжилт хүсэхэд нь их сайхан санагдсан... Анх их сургуульд орохдоо хүүхдүүд юу гэж бодох бол гэсэн жаахан айдас байсан ч хүүхдүүд бүгд л тусламж хэрэгтэй байгааг асууж, зелдэг харилцдаг нь таатай байдаг. Би сэтгэл судлалын ангиа төгсөөд, хөгжлийн ялгаатай, түүндээ сэтгэл дундуур байдаг хүүхдүүдэд туслах, өөртөөгөө адилхан дүү нартаа суралцах итгэл, урам зориг өгмөөр байна.”



*Б.Жавзан, Хөвд их сургуулийн оюутан, Хөвд их сургуулийн үүдний танхим, 2023.12.20*



# ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотын гурван дүүрэг, Өвөрхангай болон Ховд аймгийн зорилтот сургуулиудын бага, дунд ангийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

## ✓ ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

- 1 Зорилтот сургуулийн 5-р ангийн сурагчдыг дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх;
- 2 Суурь боловсролын түвшинд тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох;
- 3 Зорилтот сургуулийн эцэг эхчүүдэд хүүхдийнхээ анги дэвших болон цаашид суралцах үйл явцад туслахад дэмжлэг үзүүлэх;
- 4 Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, тэгш хамруулан сургах боловсролын төрийн бодлогод тусгах

## ₮ ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Япон улсын Гадаад Хэргийн Яам

## 🕒 ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

3 жил (2021 оны 3 сар - 2024 оны 3-р сар)

## 👤 ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД:

**Шууд:** 20,606    **Шууд бус:** 28,650

## 🏠 ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БҮЙ ЕБС-ИУД

Баянзүрх дүүргийн 79, 127, 30-р сургууль,  
Амгалан цогцолбор сургууль  
Чингэлтэй дүүргийн 37, 49, 39, 61-р сургууль  
Сонгинохайрхан дүүргийн 67, 65, 9, 76-р сургууль  
Өвөрхангай аймгийн 2-р сургууль, Уянга сумын 1-р сургууль  
Ховд аймгийн 7, 3-р сургууль



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Аризона төв, 4-р давхар  
☎ +976-11-329365, +976-11-329371  
📠 +976-11-329361

✉ secretary@savethechildren.mn  
🌐 mongolia.secretary@savethechildren.org  
📘 Save the Children in Mongolia  
🇺🇸 Save the Children MN